

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 04 сарын 24 өдөр

№ /

Арвайхээр сум

“Баянтээг” ХК-ийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 10 цаг 10 минутад Өвөрхангай аймгийн “Нутгийн удирдлагын ордон”-ны 203 тоот хурлын танхимд эхлэв.

Хурлын дарга О.Батжаргал.

Хурлын дарга: “Баянтээг” Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 69.4 дэх заалт, компанийн дүрмийн 6.12 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 93.54%-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг нээв.

Хурлаар хэлэлцэх асуудлуудын жагсаалт:

- а. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайлан;
- б. Аудитын хорооны тайлан дүгнэлт;
- с. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2019 оны цалин урамшуулал болон зардлын төсөв;
- д. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- е. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураав.

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 93.54% буюу 236,277 ширхэг хувьцаа эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигчийн саналыг саналын хуудсаар авсан ба 2 буюу 100% хүчинтэй байлаа.

1. Компанийн 2018 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг хувьцаа эзэмшигчдийн 74.84 % нь зөвшөөрсөн, 25.16 % нь татгалзсан, 0.00% нь түдгэлзсэн байна.
2. Аудитын хорооны тайлан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн 0.00% нь зөвшөөрсөн, 100% нь татгалзсан, 0.00% нь түдгэлзсэн байна.
3. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын 2019 оны цалин урамшуулал болон зардлын төсвийг хувьцаа эзэмшигчдийн 74.84% нь зөвшөөрсөн, 25.16% нь татгалзсан, 0.00% нь түдгэлзсэн байна.
4. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн 74.84% нь зөвшөөрсөн, 25.16% нь татгалзсан, 0.00% нь түдгэлзсэн байна.

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 93.54% буюу 236,277 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгөв.

Ердийн гишүүдэд:

№	Нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Д.Энхбат	14.286%	236,277
2	Д.Нэмэхбаяр	14.286%	236,277
3	Г.Баясгалан	14.286%	236,277
4	О.Батжаргал	14.286%	236,277
5	И.Доржсүрэн	14.286%	236,277
6	Ю.Батсайхан	14.286%	236,277
7	Д.Миеэгобмо	14.286%	236,277


Хараат бус гишүүдэд:

№	Нэр	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
8	Р.Өлзийжаргал	31.290%	295,729
9	З.Дашзэвгэ	31.290%	295,729
10	Г.Батсүх	18.710%	176,825
11	Л.Энхбат	18.710%	176,825

тус тус санал авч, эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурал 12 цаг 25 минутанд өндөрлөв

Дарга
Тамга



О.Батжаргал